

Эхэд тулгуурлан багц даалгаврууд гүйцэтгэх тул доош гүйлгэн бүх даалгаврыг ажиллана уу!

Насны дурсгал (Хөрөг найруулал)

1. Лодойхүү гуайн сураг

Шаргын говь. Дарвийн нуруу, Алтайн нурууны хооронд сунайн чилсэн Шаргын их говийг Цаст Сутаг дэрлэж Бурхан Буудайг жийж нойрссон аварга биетэнтэй зүйрлэж болмоор санагдана.

Зургаадугаар сарын гандуу халуун өдөр Тонхилоос Цээл хүртэл энэ их говийг туулан явахад нүд амрааж, сэтгэл чийглэх ногоон өнгө үгүйлэгдэн, тэртээд Шаргын цагаан нуур энэ хөндийг чийглэж чадаагүйдээ бачимдсан доголлон нулимс шиг цийлнэ. “Хэдхэн жилийн өмнө тэмээ үзэгдэхгүй их заган ой байж билээ” гэж нутгийн жолоочийн харамсан өгүүлэх дууны үргэлжлэл болж бөхөнгийн хөлөөр боссон тоос дуртгалын сорви шиг зураа татна.

Ийнхүү сэтгэл чилж явахад гэнэт шувуу жиргэсэн ногоон төгөл тааралдах нь цангасан хүн устай тааралдах лугаа адил болж, байгалийн баян бүрдээс шал ондоо, хүний гараар боссон ой байхад нь хэн гэдэг буянтай хүн тарьж ургуулсан юм бол гэсэн сониуч хүсэл аяндаа төрнө. Шарга, Цээл сумаар явахад л гэнэт гэнэтхэн тааралдах ногоон төглүүд Лодойхүү баатрын энд ажиллаж байсны дурсгал болон үлдэж, ажилсаг, ухаалаг энэ хүний алдрыг магтан дуулах мэт шулганан шуугьж байна.

Өвгөн баатрыг олж уулзахад амаргүй ажээ. Лодойхүү гуайн одоо зөвлөгчөөр нь ажиллаж байгаа “Жаран жил” хоршоолол дөрвөн бригадтай. “Гурван жаргалан”, “Халиун гол”, “Завхан гол”, “Буур” бригад хоорондоо зайтай боловч баатарт хүрэхгүй газар, завдахгүй ажил гэж үгүй, нэг харахад энд, нэг мэдэхэд тэнд явна. Шаргын говийн уулзсан хүн бүр, учирч тохиолдох мод төгөл хүртэл Лодойхүү гуайн ажилсаг чанарыг магтан одоо ч гэсэн өндөр насны тэтгэвэрт гарсан жаран найман насандаа ой тарьж, жимсний мод ургуулж байгааг нь бахархан ярьж байна. Шаргын говь өнгөрсөн ирээдүй хоёроороо, дурсамж зөгнөл хоёроороо төрсөн хүүгийнхээ тухай өгүүлж байна.

2. Лодойхүү гуайн бодол

Тийм ээ. Би насаараа л юм ургуулж, үржүүлж, тарьж, соёолуулж явна. Мөн өсгөж үзлээ, болдог л юм. Тариа ногоо тарилаа, ургадаг л юм. Хүний оюун ухаанд сайн үр суулгаад бордож, тордож үзлээ. Хүнээр ажил хийлгэж, хүнд ажлын амт мэдүүлэх талаар туршлагажжээ. Гэхдээ энэ бүхэн чинь хийгээд л өнгөрчихсөн ажил шүү дээ. Ер нь Лодойхүү гэдэг хүн амьдарч ажиллаж явсны дурсгал гэж Шаргын говьд юу үлдэх юм бэ? Мал өсөхдөө өсөж, хорогдохдоо хорогдож л байдаг амьтан. Тариа яах вэ, их ургац авлаа гэхэд нэг л намар шүүгиад өнгөрнө шүү дээ. Хамт ажиллаж, жаргаж зовж явсан хүмүүс нэг л үеэрээ дуусаад өгнө. Тэгэхлээр би чинь хойч үедээ ямар бэлэгтэй хүн бэ? Надаас юу үлдэх юм бол? гэж бодоод, тунгаагаад байвал явж явж энэ хэдэн мод юм гээч !

Шаргын говьд ой шуугьж, үр ач нар маань нутгийн жимс идэж, Алтайн тэнгэр бороошиж байвал амьд явсны хэрэг бүтэх нь тэр. Миний тарьсан моднууд насны минь дурсгал юм шүү. Төрөлх Шаргын говь хөглөгөр ногоон хөвч болохын удиртгал хөгжим, ирээдүй хойчоо их үйлсэд дуудсан уриа юм шүү...

Ж. Лхагва 1984 он

Монгол хэлний даалгаврууд

1. Эхийн дэвшүүлсэн асуудлыг олоорой.

- A. Ажилсаг хүний гараар аясын салхи ч бөмбөрнө.
- B. Говьд төгөл ургуулж болдог юм.
- C. Амьд явсны гэрч бол хийж бүтээсэн зүйл.
- D. Насны дурсгалаа бүтээх хэрэгтэй.

2. Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
 - A. Шаргын говьд ой шуугьж, үр ач нар маань нутгийн жимс идэж, Алтайн тэнгэр бороошиж байвал амьд явсны хэрэг бүтэх нь тэр.
 - B. Миний тарьсан моднууд насны минь дурсгал юм шүү.
 - C. Надаас юу үлдэх юм бол? гэж бодоод, тунгаагаад байвал явж явж энэ хэдэн мод юм гээч !
 - D. Ийнхүү сэтгэл чилж явахад гэнэт шувуу жиргэсэн ногоон төгөл тааралдах нь цангасан хүн устай тааралдах лугаа адил
3. Эхэд өгүүлэгдэх суурь мэдээлэл буюу эхлэл хэсэг нь аль вэ?
 - A. Шаргын говийн уулзсан хүн бүр, учирч тохиолдох мод төгөл хүртэл Лодойхүү гуайн ажилсаг чанарыг магтана.
 - B. Шарга, Цээл сумаар явахад л гэнэт гэнэтхэн тааралдах ногоон төгөлүүд Лодойхүү баатрын энд ажиллаж байсны дурсгал.
 - C. “Говь газар юу ч ургахгүй биш, тарьж ургуулж болдог юм” гэсэн яриа.
 - D. Шаргын цагаан нуур энэ хөндийг чийглэж чадаагүйдээ бачимдсан бачимдал, заган ой байсныг дурссан нутгийн жолоочийн харамсал
4. “Ер нь Лодойхүү гэдэг хүн амьдарч ажиллаж явсны дурсгал гэж Шаргын говьд юу үлдэх юм бэ?” хэмээн өөрөөсөө асуусны хариулт аль вэ?
 - A. Би насаараа л юм ургуулж, үржүүлж, тарьж, соёолуулж явна.
 - B. Бодоод, тунгаагаад байвал явж явж энэ хэдэн мод юм гээч !
 - C. Тариа яах вэ, их ургац авлаа гэхэд нэг л намар шуугиад өнгөрнө шүү дээ.
 - D. Алтайн тэнгэр бороошиж байвал амьд явсны хэрэг бүтэх нь тэр.
5. “Шаргын говийн уулзсан хүн бүр, учирч тохиолдох мод төгөл хүртэл Лодойхүү гуайн ажилсаг чанарыг магтана” гэсэн санааг батлах баримт аль вэ?
 - A. Шарга, Цээл сумаар явахад л гэнэт гэнэтхэн тааралдах ногоон төгөлүүд.
 - B. Байгалийн баян бүрдээс шал ондоо, хүний гараар боссон ой байв.
 - C. Ийнхүү сэтгэл чилж явахад гэнэт шувуу жиргэсэн ногоон төгөл тааралдав.
 - D. Би насаараа л юм ургуулж, үржүүлж, тарьж, соёолуулж явна.
6. “Зургаадугаар сарын гандуу халуун өдөр Тонхилоос Цээл хүртэл энэ их говийг туулан явахад нүд амрааж, сэтгэл чийглэх ногоон өнгө үгүйлэгдэнэ” гэсэн өгүүлбэрийн “сэтгэл чийглэх” гэсэн сонин содон дүрслэлийн утгыг илэрхийлсэн нь аль вэ?
 - A. Зун цагийн
 - B. Нүдэнд дассан
 - C. Таатай сайхан
 - D. Газар норгосон
7. Юуг, ямар шинжээр нь аварга биетэнтэй адилтгасан бэ?
 - A. Шаргын говийг нойрсож буй дүр төрхөөр нь аварга биетэнтэй адилтгасан.
 - B. Дарвийн нуруу, Алтайн нурууны хоорон дахь Шаргын говийг хэлбэр хэмжээгээр нь аварга биетэнтэй адилтгасан.
 - C. Бурхан Буудай уулыг жийж тогтсон байрлалаар нь аварга биетэнтэй адилтгасан.
 - D. Цаст Сутай уулыг дэрлэж тогтсон байр байдлаар нь аварга биетэнтэй адилтгасан.
8. Онцолсон хэсгийн аль үгийг “угтаа” гэх үгээр солин найруулахад найруулгад өөрчлөлт орохгүй вэ?
 - A. Гэхдээ
 - B. Ер нь
 - C. Тэгэхлээр
 - D. гэж
9. Чи өөрийгөө Шаргын говиор аялж явна гэж төсөөл. Лодойхүү гуайн өөрийн гараар бүтээсэн ногоон төгөлтэй таараад түүний ажилсаг байдалд атаархсан үг хэлсэн бол чиний хэлсэн үг аль нь вэ?
 - A. Лодойхүү гуай Шаргын говийг бүхлээр нь ийм төгөл болгочихвол мөн ч гоё.
 - B. Энэ хэсэгт амьтад ирж, амьдрал бужигнах боломжтой юу?
 - C. Энэ их говьд ийм сайхан ногоон төгөл бас байдаг аа!
 - D. Их говийн уудамтай харьцуулахад бол багахан ч гэсэн сайхан төгөл болжээ.

10. “Хүний оюун ухаанд сайн үр суулгаад бордож, тордож үзлээ” гэх өгүүлбэрийн “үр” гэсэн үг өгүүлбэрт ямар гишүүн болох вэ?

- A. Өгүүлэхүүн
- B. Өгүүлэгдэхүүн
- C. Тусагдахуун
- D. Байц

11. “Шаргын говийн уулзсан хүн бүр, учирч тохиолдох мод төгөл хүртэл Лодойхүү гуайн ажилсаг чанарыг магтан, одоо ч гэсэн өндөр насны тэтгэвэрт гарсан жаран найман насандаа ой тарьж, жимсний мод ургуулж байгааг нь бахархан ярьж байна.” Тодруулсан холбох бүтээврүүдийг зэрэгцүүлэн холбох, угсруулан холбох бүтээврээр нь зөв ялгасан нь аль вэ?


- A. Зэрэгцүүлэн холбох : -сан, -ж, -н, -сан, -ч
Угсруулан холбох : , -ж
- B. Зэрэгцүүлэн холбох : -ч, -н, -ж
Угсруулан холбох : -сан, -х
- C. Зэрэгцүүлэн холбох : -н, -сан, -ж, -ч
Угсруулан холбох : -сан
- D. Зэрэгцүүлэн холбох : -ж, -н, -сан, -ж байгаа нь
Угсруулан холбох : -сан, -ч

12. Дээд найруулгын үг ашиглан бичсэн нь аль вэ?

- A. Бурхан Буудайг жийсэн аварга биетэнтэй зүйрлэж болмоор санагдана.
- B. гэнэт шувуу жиргэсэн ногоон төгөл тааралдах нь цангасан хүн устай тааралдах лугаа
- C. Энэ хүний алдрыг магтан дуулах мэт шулганан шуугьж байна.
- D. Нүд амрааж, сэтгэл чийглэх ногоон өнгө үгүйлэгдэн

Үндэсний бичгийн даалгаврууд

13. Хулсан үзгийн тигээр бичсэн эхийг зөв хөрвүүлсэн нь аль вэ?



- A. Хомнолдоод тохсон хангайн
Хорин дөрвөн оргил
Халдун Бурханыг өвөрлөсөн
Хан Хэнтий уул
- B. Хомнолдоод тогтоосон хангайн
Хорин дөрвөн оргил
Халдун Бурханыг өвөрлөсөн
Хан Хэнтий уул
- C. Хунилдаад тогтсон хангайн
Хорин дөрвөн оргил
Халдун Бурханыг өвөрлөсөн
Хан Хэнтий уул
- D. Хомнолдоод тогтсон хангайн
Хорин дөрвөн оргил
Халдун Бурханыг өвөрлөсөн
Хан Хэнтий уул

14. Үндэсний бичгээр бичсэн дараах үгийг уншаад утгыг зөв тайлбарласныг олно уу?

ᠮᠤᠨᠤᠯᠤᠭ

A
ᠨᠠᠨᠤᠯᠤᠭ

B
ᠮᠤᠨᠤᠯᠤᠭ

C
ᠨᠠᠨᠤᠯᠤᠭ

D
ᠮᠤᠨᠤᠯᠤᠭ

15. Дараах өгүүлбэрийг үндэсний бичгээр зөв бичсэн нь аль вэ?
Анд андгай гэдэг үгс нь нэг язгууртай ажээ.

A
ᠠᠨᠳᠤᠨᠠᠨᠳᠤᠭᠠᠢᠭᠡᠳᠡᠭᠦ᠋ᠭᠦ᠋ᠭᠦ᠋ᠨᠠᠵᠢᠭᠡᠰᠡᠭᠡᠢ

B
ᠠᠨᠳᠤᠨᠠᠨᠳᠤᠭᠠᠢᠭᠡᠳᠡᠭᠦ᠋ᠭᠦ᠋ᠭᠦ᠋ᠨᠠᠵᠢᠭᠡᠰᠡᠭᠡᠢ

C
ᠠᠨᠳᠤᠨᠠᠨᠳᠤᠭᠠᠢᠭᠡᠳᠡᠭᠦ᠋ᠭᠦ᠋ᠭᠦ᠋ᠨᠠᠵᠢᠭᠡᠰᠡᠭᠡᠢ

D
ᠠᠨᠳᠤᠨᠠᠨᠳᠤᠭᠠᠢᠭᠡᠳᠡᠭᠦ᠋ᠭᠦ᠋ᠭᠦ᠋ᠨᠠᠵᠢᠭᠡᠰᠡᠭᠡᠢ

16. “Цагаан гэрт хааны хүүд тэнцэх сайхан эхнэрийг олов” гэсэн өгүүлбэрийн *гэрт* гэх үгийг яаж бичих вэ?

A
ᠭᠡᠷᠲᠦ

B
ᠭᠡᠷᠲᠦ

C
ᠭᠡᠷᠲᠦ

D
ᠭᠡᠷᠲᠦ

17. Монголын нууц товчооны хэсгээс уншаад хуучирсан үг хэллэгийг олоорой.

A
ᠨᠠᠨᠤᠯᠤᠭ

B
ᠨᠠᠨᠤᠯᠤᠭ

C
ᠨᠠᠨᠤᠯᠤᠭ

D
ᠨᠠᠨᠤᠯᠤᠭ

Уран зохиолын даалгаврууд

18. Монголын Нууц Товчооны

“Мөчир бүрээс
Мөч гуя өлгөж
Хожуул бүрээс
Хоёр гурван шувуу олгосон” хэмээх дүрслэл зохиолч Ж.Саруулбуяны
“Бодончар Богд” өгүүллэгийн аль үйл явдалтай холбогдох вэ?

- A. Бодончар богд ах нарын мунхгаас болж өвсөн эмбүүлд толгой хоргодож байсан
- B. Харцага нь нугас галуу барих уран аргыг төвөггүй сурч, эзнээ тэжээж эхэллээ
- C. Бодончар орогшин хул мориныхоо согсоо гөхлийг ширтэн гэлдрүүлж явна
- D. Бодончар тэр иргэнийг эзлэхэд тун хялбар хэмээн бодов

19. Монголын Нууц Товчоонд бусад овог аймгийнхан Жамухыг харь овгийнх хэмээн гадуурхдаг байсан тухай тэмдэглэсэн байдаг. Чухам юуны учир харь хэмээн гадуурхсан бэ?

- A. Олзонд жирэмсэн ирсэн урианхайжингийн төрүүлсэн үр удам учраас
- B. Жадаран овог өөр газраас нүүж ирсэн учраас
- C. Бодончар дээдсийн татвар эмээс гарсан хүний үр удам учраас
- D. Бодончар дээдсийн холд цөлсөн овгийн үр удам учраас

20. Монголын нууц товчоо зохиолын Тоорил ханы хэлсэн дараах үгэнд шүлгийн айзам, эгшиглэл хэрхэн илэрснийг зөв тайлбарласан хэсэг аль вэ?

Булган дахын чинь хариуд
Бутарсан улсыг чинь
Бөөгнөрүүлж өгье

- A. “Б” авиагаар толгой холбон шүлэглэсэн нь эгшиглэлийн хувьд уншихад уран яруу, айзам хэмнэлтэй сонсогдож байна.
- B. Гурван мөрөөр толгой холбон шүлэглэхдээ мөр бүр дэх үгийн тоо тэнцүү биш байгаа нь монгол шүлгийн тогтсон загварыг эвдсэн.
- C. Шүлгийн бүтэц алдагдсан, уншихад нэг хэмнэлд орохгүй, хамжин шүргэх “б” авиагаар толгой холбосон нь тийм ч оновчтой эгшиглэл биш байна.
- D. Монгол шүлгийн гурван мөртийн сонгодог жишээ бөгөөд толгой холбож утгыг илэрхийлсэн нь уншихад айзам хэмнэлтэй, эгшиглэл сайтай болжээ.

21. Монголын нууц товчоо зохиолд

Харь улсыг үл довтлон
Хацар сайт охидоо
Хасаг тэргэнд суулгаж
Хатируулж одож
Хатан сууринд дэвшүүлдэг нэгэн овог аймаг байдаг нь аль вэ?

- A. Тайчууд
- B. Жадаран
- C. Жүрхин
- D. Хонгирад

22. “Бодончар Богд” өгүүллэг нь “Монголын нууц товчоо”-ны аль хам сэдвээс сэдэвлэсэн зохиол вэ?

- A. Энгийн амьдралын арга ухааныг өгүүлсэн тул ахуйн соёлын хам сэдвээс сэдэвлэсэн зохиол.
- B. Түүхэн цаг үеийн талаар өгүүлсэн тул түүхийн хам сэдвээс сэдэвлэсэн зохиол.
- C. Ихэс дээдсийг шүтээнийг шүтэн дээдэлж буй тухай өгүүлсэн тул шашны хам сэдвээс сэдэвлэсэн зохиол.
- D. Хаан язгууртны мандал, буурлын талаар өгүүлсэн тул улс төрийн хам сэдвээс сэдэвлэсэн зохиол